



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2017 оны 11 дугаар сарын 21

№ 01/83

Мандалговь хот

**Г Зөрчил арилгуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2 заасан бүрэн эрхийн хүрээ, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 203 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайллангийн аудитын журам”-ын 1.9 дэх заалт, аймгийн Аудитын газрын 2017 оны бүтгэгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дэрэн сумын Цэцэрлэгийн 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрлын аудит хийх явцад батлагдсан жишиг хэмжээг мөрдөөгүй нийт 12,300,877.00 /арван хоёр сая гурван зуун мянга найман зуун дөлөн долоо/ төгрөгийн хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 04 сарын 08-ны өдрийн 113 тоот тушаалаар баталсан “Цэцэрлэг, сургуулийн наслын хүүхдийн хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэмжээ, дэглэм”-ийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага вэгэх, хууль тогтоомж, эрх зүйжэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтын нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага вэгэх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.5-т /Хууль тогтоомж зөрчсон алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтийг гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Нормативт зардлыг хяналтгүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биселтийг 2017 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийн Дэрэн сумын Цэцэрлэгийн эрхлэгч Р.Нэргүй, нягтлан бодогч

II. Оюунчимэг нарт хариуцуулав

 <b>ОҮНЧИМЭГ</b> <b>АУДИТОР</b>  <b>Ч.ГАНТУЯА</b> 4817144213 ЗЮА0039 902 475
--

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ЗӨВШӨӨРСӨН:**

ЭРХЛЭГЧ   
**Р.НЭРГҮЙ**  
 НЯГТЛАН БОДОГЧ   
**НЯГТЛАН БОДОГЧ**   
**П.ОЮУНЧИМЭГ**

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлээ/